



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.07.24 № 185

танай _____ -ны № _____ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Говь-Алтай аймгийн Шинэ намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

0702-00629

Дүгнэлт

Говь-Алтай аймгийн Шинэ намын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Говь-Алтай аймгийн Шинэ намын мөрийн хөтөлбөр (...⁴... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Говь-Алтай аймгийн Шинэ намд

Хувийг: Говь-Алтай аймгийн Сонгуулийн хороонд

Хавсралт ...⁴... хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА



“ШИНЭ СОНГОЛТ-ШИНЭ МОНГОЛ”

*Говь-алтай аймгийн ИТХ-ийн хурлын
сонгуулийн мөрийн хөтөлбөр - 2024*

Улаанбаатар хот
2024 он

УДИРДТГАЛ

Улс эх орон болон аймаг орон нутаг эзэнтэй байх тулгуур үндэс нь ард иргэдийн ахуй амьдралын таатай орчин хэр зэрэг бүрдсэн байна, таатай амьдрах нөхцөл бүрдүүлэх эдийн засгийн боломж бололцоог төр засгаас хэрхэн хангаж байгаа байдал нь шийдвэрлэх ач холбогдолтой байсаар ирсэн.

Орон нутгийн хөгжил гэдэг нь улс төрийн талцал хуваагдал, орон нутгийн явцуу эрх ашгаас илүүтэйгээр үндэсний эрх ашгийг дээгүүр тавьж, нутаг дэвсгэрийн төлөвлөлт, хөгжлийн асуудлыг цогцоор авч үзэн бүс нутаг бүрийн нөөц, чадавхыг нийтлэг эрх ашгийн төлөө оновчтой ашиглах, аймаг, нийслэл, сум, хорооны хоорондын харилцан хамаарал, хамтын ажиллагааны механизмыг үр дүнтэй ашиглах, байгалийн баялагийг үр шим, өгөөжийг бодитоор хүртдэг болох нь хүн амын шилжилт хөдөлгөөний эерэг, сөрөг үр дагавртай шууд хамааралтай.

Үндсэн хуулийн 3.1 “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна” гэсэн зарчмыг аймаг, нийслэл, орон нутгийн хэмжээнд бүрэн хэрэгжүүлж цомхон, хязгаарлагдмал, хариуцлагатай, ардчилсан, нийгэмд тэгш үйлчилдэг засаглалыг бий болгож иргэд нь өөрсдөө хийж чадах ажлыг орон нутгийн түвшинд өөрсдөө шийддэг, аймаг, нийслэл, сум хорооны хөгжлийг төр засгийн хязгаарлагдмал оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

Орон нутгийн хэмжээнд улстөрийн намын бүтэц ажиллахыг хязгаарлан, төрийн алба, ард иргэд нь намаар талцдаг байдлыг зогсоож, авлигыг устган, сум хороондоо сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлнэ.

Сум хороонд эдийн засгийн эрх чөлөөг олгосноор арилжаа худалдаа, аялал жуулчлал, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хөгжил цэцэглэх, орон нутгийн бүтээн байгуулалтад нутгийн иргэд, ААН давуу байдалтай оролцдог байх боломжийг нээж өгснөөр орон нутаг эзэнтэй байх нөхцлийг бүрдүүлнэ. Эдгээр зорилгыг хэрэгжүүлэхийн тулд 2024 оны аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн хурлын төлөөлөгчдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг дэвшүүлж байна.

1. НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ ЁСНЫ ЗАРЧМЫГ БЭХЖҮҮЛНЭ

Хүний жам ёсны эрх болсон амьд явах, эрх чөлөөтэй байх, өмчлөх эрхийг эрхэмлэн дээдэлсэн, иргэдийн оролцоотой, цомхон, хяналттай, хариуцлагатай нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг бэхжүүлнэ. Орон нутгийн чанартай аливаа ажлыг нутгийн иргэдийн санал, шийдвэрийн дагуу өөрсдөө хийж чадах бүхнийг нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүд гүйцэтгэн хийдэг байх эрх мэдлийг олгоно.

2. БАЯЛАГИЙН ӨГӨӨЖИЙГ МОНГОЛ ХҮН ХҮРТЭНЭ

Стратегийн ордод тооцогдсоноос бусад орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа эрдэс түүхий эд, байгалийн баялаг, ордыг ашиглах, олборлох. бусдад ашиглуулах эрхийг тухайн орон нутгийн иргэдийн олонхийн саналаар шийдвэрлэж байх эрх мэдлийг орон нутгийн иргэдэд олгоно.

3. АЖ ҮЙЛДВЭРИЙН ХУВЬСГАЛ

Байгалийн баялаг, эрдэс түүхий эд, мал, малын гаралтай бүтээгдэхүүн, тэдгээрийн боловсруулалт, газар тариалан, эрдэм мэдлэг-оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл үйлчилгээнд төрөөс үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлж, хиймэл оюун ухаан, техник технологийн дэвшил ашигласан, орон нутагт ажлын байр, ажилчдын цалин хөлс нэмэгдүүлэх, иргэдийн шилжилт хөдөлгөөнийг сааруулсан аж үйлдвэржилтийг бүхий л талаараа дэмжинэ.

4. МАЛ АЖ АХУЙ- ГАЗАР ТАРИАЛАН

Мал аж ахуйн талаар төрөөс баримтлах бодлогыг дэмжин ажиллах, малын гаралтай бүтээгдэхүүн болох мах, сүү, цагаан идээ боловсруулах нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, газар тариаланг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай услагааны системийг нэмэгдүүлнэ.

5. БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Монгол улсын түүх, соёл, үндэсний өв уламжлал, нүүдэлчин ахуйн ёс заншил, байгалийн үзэсгэлэнт газруудыг гадаад дотоодын жуулчдад таниулах, дөрвөн улирлын аялал жуулчлалыг аймаг болон бүсийн онцлогт тохируулан хөгжүүлэхэд бүс хоорондын уялдаа холбоо, хамтын ажиллагааг сайжруулна.

6. МОНГОЛ ТӨРИЙН ҮНДЭС – ХҮЧИРХЭГ МОНГОЛ ГЭР БҮЛ

Төр улсын үндэс - монгол өрх, гэр бүлийг ирээдүйдээ итгэлтэй, амар амгалан амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор иргэн бүрийг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын чанартай, хүртээмжтэй үйлчилгээнд хамруулна. Хүүхэд бүрт чанартай, тэгш, хүртээмжтэй боловсролыг олгохын тулд багш нарын чадавх, цалин хангамжийг сайжруулан “Хамгийн сайн сургууль бол гэртээ хамгийн ойр сургууль” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгэмд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх, тэдэнд үзүүлэх нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээг сайжрууна.

8. ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ, ОЮУН САНААНЫ СЭРГЭЛТ

Үндэсний өв уламжлал, ёс заншил, түүхэнд шингэсэн мэдлэгээ хүүхэд залуус, хойч үедээ өвлүүлэн үлдээж, иргэн бүрт эх орон, газар шороо, тусгаар тогтнол, Үндэсний аюулгүй байдал, иргэдийн заяагдмал эрхийг хамгаалсан бодлого хэрэгжүүлж, их түүх, соёлын өв, үндэсний үнэт зүйлээ хамгаалах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлнэ.